

# BIZNETWORK.MN

Хүний нооцийн салбарын мэдээ мэдээлэл, статистик судалгаа, зөвлөгөөг агуулсан цахим сэтгүүл



Biznetwork.mn эмнэлэг,  
эрүүл мэндийн  
салбарыг онцоллоо




Хөдөлмөр  
эрхлэлт ба  
Ажилгүйдэл



Анхаарлын эдийн  
засагт та үнэт цагаа  
үрсээр байх уу?

“Амазон бусад компанийг цалингаа нэмэгдүүлэхэд  
хүргэж мэднэ”



“Biznetwork.mn эмнэлэг эрүүл  
мэндийн салбарыг онцоллоо”



“Амжилтад гурван зүйл чухал.  
Тэр нь итгэл, сэтгэл, зүтгэл”



# Biznetwork.mn эмнэлэг эрүүл мэндийн салбарыг онцолж байна



Biznetwork.mn-д 24 салбарын 20000 ажлын байрны зар идэвхтэй зарлагдаж байгаагаас өдөрт дунджаар 400 гаруй ажлын байрны зар тогтмол нийтлэгдэж байна. Бид үндсэн үйл ажиллагаанаасаа гадна “Хүний нөөцийн сонгон шалгаруулалт”, “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа”, “ERP систем хөгжүүлэлт” “Бизнетворк Академи”-ийн сургалт, өөрийн мэдлэг чадвараа баталгаажуулах шалгуур зэрэг хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн олон ажлыг амжилттай хийж байгаа билээ.

Бид 2019 оны 01 дүгээр сарыг эрүүл мэндийн салбарын сар болгон зарлаж байгаа бөгөөд тус салбарын хамтран ажиллагч байгууллагуудаас дурдвал Улсын клиникийн 1-р төв эмнэлэг, Шастины нэрэмжит 3-р төв эмнэлэг, Монос групп, Интермэд эмнэлэг, Гурван гол эмнэлэг, Мөнгөн гүүр эмнэлэг, Улаанбаатар Сонгдо эмнэлэг, Энто, Монгол эм импекс, Ачтан эмнэлэг, Баянгол юнимед интернейшил эмнэлэг, Ази фарма гэх мэт 200 гаруй байгууллагын 350 гаруй ажлын байр зарлагдаж байна. Монголын эрүүл мэндийн салбарт томоохон байр суурь эзэлдэг, чухал үүрэг хариуцлагатай ажил олгогч та манай сайтад бүртгүүлж бидэнтэй хамтран ажиллахад бэлэн үү?

Та манайд гишүүнчлэлээр бүртгүүлснээр:

- **Зарлаж буй ажлын байр, зорилтот хүндээ шууд хүрэх**
- **Чадварлаг боловсон хүчинээ цаг алдалгүй сонгох**
- **Цаг зав, эдийн засгийн хэмнэлттэй.**

Мөн тухайн салбарын ажил горилогч наарт зориулсан өөрийн мэдлэг чадварын түвшингээ тодорхойлох, түүнийгээ баталгаажуулах боломжийг олгохоос гадна мэдлэгт тань дусал нэмэх зорилготой сургалтуудыг үнэ төлбөргүй явуулж байна.

Тиймээс та манайд бүртгүүлж, сургалтад хамрагдаж хүссэн ажилдаа орох боломжийг бид танд олгож байна.

Одоогийн байдлаар бид 170.000 гаруй анкетын санг бүрдүүлж, 4800 гаруй гишүүн байгууллагатай хамтран ажиллаж байна.

# Амазон 2019 онд хөдөлмөрийн зах зээлд юу хийх вэ?

АНУ дахь ажил олгогчид өнгөрсөн 2018 онд чадварлаг ажиллах хүчин олох тал дээр нэлээдгүй хүндрэлтэй тулгарсан. 2019 онд ч гэсэн энэ төлөв үргэлжлэх бололтой.

Судалгаанаас үзэхэд 11 дүгээр сарын ажилгүйдлийн түвшин маш бага буюу 3,7 хувьтай байжээ. Ажилгүйдлийн түвшин бага байснаар компаниуд байнга болон улирлын чанартай ажиллах чадварлаг хүмүүсийг олох магадлал багасдаг. Экспертүүдийн таамаглаж буйгаар тус хандлага нь энэ онд дахин үргэлжлэх төлөвтэй байна. 2019 онд юу хүлээж буйг мөн ажилтан сонгон шалгаруулах болон чадварлаг ажилтнаа авч үлдэхэд ямар шинэ хандлага зонхилох талаар эдийн засагч, хөдөлмөрийн зах зээлийн шинжээчид хэрхэн дүгнэсэнтэй танилцъя.

## 1. Сонголт улам цөөрнө



Энэ онд ажил горилогч, анкет илгээгчдийн тоо хумигдах төлөвтэй байна. Үүний нэг шалтгаан бол Америкийн хөдөлмөр эрхлэх насны хүмүүсийн тоо 1980, 1990 оноос хойш хурдацтай өссөнгүй.

Мөн АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампын засгийн газраас



хэрэгжүүлж буй цагаач нарт чиглэсэн бодлого нөлөө үзүүлэх аж. Тухайлбал, АНУ-д үйл ажиллагаа явуулж буй компаниудад гадны орноос ур чадвар өндөртэй хүмүүсийг түр хугацаагаар ажиллах боломж олгодог Н-1В визад шахалт үзүүлж эхэлсэн нь нөлөөлж байна. 2017 оны нэг сараас найман сар хүртэлх хугацааг авч үзэхэд анкет ирүүлсэн дөрвөн хүн тутмын нэгд татгалзсан хариу өгсөн байхад өмнөх оны Обамагийн засгийн газрын үед тус харьцаа тавд нэг байсныг АНУ-ын иргэншил, цагаачлалын хэрэг хариуцсан үйлчилгээний газраас мэдэгдлээ. 2018 онд ч гэсэн Н-1B-ын анкет илгээгчдийн тоо дараалан хоёр дахь жилдээ буурч, 199,000-аас 190,908 болжээ. Indeed-ийн ахлах эдийн засагч Колкогийн хэлснээр

**“Цагаачлал бол удаашралтай осож буй ажиллах хүчийг нохөх нэг арга. Гэвч яг энэ үед манай бодлогоор цагаачлалыг дэмжих биш дарж байна.”**

## 2. Гадны орнуудад салбар оффис нээнэ



Гадны орнуудад салбар оффис нээж АНУ-д ажиллах зөвшөөрөл авч чадаагүй тухайн улсын ажиллах хүчинийг татна. Сүүлийн үеийн цагаачид коллежийн зэрэгтэй, Америкад төрсөн, хууль ёсны иргэншилтэй, ихэнх нь технологи, эрүүл мэнд болон шинжлэх ухааны бусад салбарт мэргэшин ажиллах болсон. Цагаачлалын асуудал ярвигтай болох тусам тус салбаруудад хэрэгтэй хүнээ ажилд авахад хүндрэлтэй тулгарах юм.

**3. Компаниудын технологид оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ**



Компаниуд хүний нөөцийн ажилтныг чадавхжуулахад хөрөнгө оруулахаас илүүтэйгээр хүний нөөцийн сонгон шалгаруултын асуудлыг шийдвэрлэх технологийг хайж олохыг илүүд үзэж байна.

Тухайлбал зарим компани олон хүн ажиллуулахгүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ хэвийн үргэлжлүүлэх замыг эрэлхийлнэ хэмээн Колко таамаглажээ. Мэдээж энэ арга нь салбар бүрт харилцан адилгүй байх чөрөнхийдөө бол гар хөдөлмөрийг автоматжуулах үүднээс хүнд биш роботод хөрөнгө оруулна.



**4. Амазон компанийн бусад компанийг цалингаа нэмэгдүүлэхэд хүргэж мэднэ**

Амазоны Виржиния муж дахь Кристал хот, Нью-Йоркийн Лонг Айланд дахь удирдлагын


төв оффист 50,000 ажлын байр шинээр бий болох гэж байна. Үүнээс үүдэн аль ч талуудад техникийн чиглэлээр төгссөн шинэ төгсөгч, инженер гэх мэт ур чадвартай ажилтны төлөөх эрэлт үүснэ хэмээн Корн Ферри зөвлөх үйлчилгээний фирмийн Жон Барней өгүүллээ.

Нью-Йорк хотод техникийн салбарынханд зориулсан эко систем хэдийнээ бүрэлдсэн байхад нийслэл Вашингтон Д.С-ийн хувьд байдал харьцангуй чанга. Ойрын хугацаанд технологи, агаарын болон сансрын хөлгийн үйлдвэрлэл, батлан хамгаалах салбарын компаниуд цалингийн түвшингээ нэмэгдүүлж, ур чадвартай хүмүүсийг тогтоон барихын тулд өрсөлдөхүйц урамшууллыг амлаж эхэнэ. Харин урт хугацаанд Вашингтон хотыг томоохон технологийн цэг болоход Амазоны дэмжлэг өндөр байна.

## 5. Компаниудын ажилтан шалгаруулах явц урьдынхаас өндөр байна



2018 оны гол стратеги болох “Ажилд хурдан ав” энэ онд ч гэсэн байр сууриа тавьж өгөхгүй нь. Барнигийн хэлснээр “Ажил горилогчдыг судлахад хурд үнэхээр чухал юм. Зах зээлийн хурдыг дагаж шаламгай хөдлөх хэрэгтэй.



Зарим компаниуд ажилтан шалгаруулах явцыг автоматжуулсан нь ажил горилогчид утсаар дуудлага хийж, автомат хариулагчийн асуултад хариулах бөгөөд үүнийг нь дуу бичигчээр хураан авч байна”.

Мөн ажил горилогчид өөрийн хувийн сонирхол, итгэл үнэмшилд нийцсэн, үнэн бодит түүхтэй, цохон тэмдэглэсэн үнэт зүйлсээ өөрсдөө даган мөрддөг компанийд ажиллахыг эрмэлзэдэг болжээ.

Энэ тохиолдолд жижиг бизнесүүд илүү давуу талтай. Учир нь тэдний санаа, хүргэж буй мессэж нь чин үнэн байхаас гадна том компаниас хурдан хөдөлж чаддаг.

## 6. Урамшуулал бол иэн чухал. Хүн төвтэй бол бүрлайн.



**“Ажлаа хүлээлгэн өгөгчийн тоог бууруулахын тулд чадвартай хүмүүсээ энд үлдэх ёстой хэмээн итгээтэл нь үнэмшиүүлэх шинэ аргатай болох хэрэгтэй”** хэмээн Корн Ферригийн гүйцэтгэх захирал Жулиана Барела зөвлөж байна. Үүний нэг нь хувь хүнд тулгуурлах төлбөрийн арга.

Тодруулбал масс бүлэгт биш харин хэсэг бүлэгт зориулсан, тэдэнд таалагдах урамшуулал, шагнал өгөх юм.

Манай байгууллагад л гэхэд дөрвөн үеийн төлөөлөл болсон хүмүүс ажиллана. Үе тус бүрийн хүлээлт ондоо тул авч буй цалин, урамшууллыг өөрөөр хардаг. Ажлын

уюн хатан цаг, илүү цагийн хөлс, гадаад руу томилолтоор явах эсвэл өөр газар суурьшин ажиллах явдлыг хүлээн авахдаа ялгаатай. Энэ аргыг мөн л жижиг компаниудад илүү амар санагдана.

Том компанийтай харьцуулахад урамшуулал, нохон олголт хийх арга шинэчлэхэд асуудал багатай буюу уян хатан. Ямартай ч компани эсвэл багт зориулсан нэгдсэн урамшуулалтай байхын оронд ажилчдаас судалгаа авсны үндсэн дээр наасны бүлэг гэх мэт чухал хүчин зүйл дээр тулгуурлах нь зүйтэй.

Эх сурвалж: [www.inc.com](http://www.inc.com)

# Хөдөлмөр эрхлэлт ба Ажилгүйдэл

Энэ бүлэгт хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, ажиллагчид, ажилгүй иргэдийн талаарх мэдээллийг тусгалаа. Эдгээр үзүүлэлтийг тооцохдоо Үндэсний статистикийн хорооноос жил, улирал тутам гаргадаг хөдөлмөрийн статистикийн холбогдолтой түүвэр судалгаа, мэдээ тайлангийн үр дүнг ашигласан болно.


## АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН САЛБАРААР



НИЙТ  
1 238 869



НИЙТ АЖИЛГҮЙ ИРГЭД 92397



Ажилгүйдлийн түвшин

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо  
2018 оны 3-р улиралын тайлан

# Ч.Лодойравсал: Том компаниуд диплом биш, хувь хүний гурван чадварыг л голчлон хардаг

**МУИС-ийн ТУЗ-ийн гишүүн, ХШУИС-ийн дэд профессор Ч.Лодойравсал “МУИС-ийн индер” зочноор уригдан “Бүтээгч монгол, бүтээгч иргэн-МУИС-ийнхан” сэдвээр тавьсан илтгэлийг тоймлон хүргэж байна.**



Яг одоогийн Монгол Улсын хувьд хамгийн том асуудал нь хэрэглэгч улс болчоод байгаа юм. Ихэнх тохиолдолд бүх бараа бүтээгдэхүүнээ импортолж байна. Бидний экспортолж байгаа бүтээгдэхүүн маш бага, тэр дотроо ихэнх нь түүхий эд байх жишээтэй. Тэгэхээр дараагийн бидний зорилт бол үйлдвэрлэгч улс болох юм. Бид өөрсдөө хийж, бүтээж сурас ёстой. Монгол Улс ган хайлуулах ёстой, хүнд машины үйлдвартай байх ёстой. Мал аж ахуй, газар тариалантай байх ёстой. Өөрөөр хэлбэл, бид бусдаас хараат болохгүйн суурь үндэс нь үйлдвэрлэгч байх ёстой юм. Шинэ технологи, шинэ мэдлэг бүтээдэг, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлд явах нь чухал. Улс орон ийм чиглэлд явах ёстой бол иргэд нь мөн л адил бүтээлч байх шаардлагатай. Тэгж байж бид цааш явна.

Бид анхнаасаа л хэрэглэгч орон байсан уу гэвэл бас үгүй. Манайд өнгөт телевизор, компьютер угсарч байсан туршлага ч бий. Монгол Улс бодлоготойгоор электроникийн салбарт Зүүн өмнөд Ази, Польш, Чех зэрэг орнуудад электроникийн инженерүүд бэлдсэн. Тэгээд улсаас 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд "Монел" компанийг байгуулаад үйлдвэр явуулж байсан. 2012 оны мэдлэгийн эдийн засгийн индекс Монгол Улс 83-д байсан бол Хятад 84-д эрэмбэлэгдэж байлаа. Хятадаас 10 мянган хүнд ногдох телевиз, гар утас, интернэт хэрэглээгээрээ өндөр байсан. 1946 онд Х.Чойбалсан ШБОС буюу шинэ бүтээл оновчтой санаачилга гаргаж хумууст

олсон орлогоос нь 20 хувийг урамшуулал болгон өгч байсан. 1980 онд ШБОС-ын дэлгэрүүлэх аян улс даяар өрнөсөн. Үүний үрд дүнд Азид байхгүй мундаг систем хийсэн шүү дээ. Яамдын орлогч дарга, сайд нараас эхлээд, төсөв баталдаг хүний ажил үүргийг хүртэл ШБОС гэдэг үзүүлэлтээр үнэлж байлаа. Үүний хүчинд 1980-1990 он хүртэл 10 жилийн хугацаанд 20 мянган шинэ патент бүртгэгдэж байсан. Түүнээс 90 хувь нь амьдралд нэвтэрч байсан. Бидэнд одоо энэ мэт зөв бодлого маш чухал. БНСУ-ын технологиор амжилт олсон туршлага их энгийн. 1980-аад оны сүүлээр БНСУ-д байгууллагын холбооны системийг бүгдийг шинэчлэх шаардлага гарсан. Яг тэр үед Солонгосын ахисан түвшний судалгааны институт /КАИСТ/-ийн профессор Ерөнхийлөгчдөө хандаж “Үүнийг бид хийж чадна, үүнийг л бид өөрсдөө хийхгүй бол цаашид бүгдийг худалдаж авах болно шүү” гэж захияа бичсэн байдаг юм. Тэгээд Ерөнхийлөгч нь шийдвэр гаргаад түүнийг хийж чадах бүх хүнийг цуглуулаад хийлгэсэн. Технологийн салбарын хөгжил нь ингэж эхэлсэн түүхтэй. Тэгвэл үйлдвэрлэгч бүтээгч улс болоход хүмүүс нь ямар байх ёстой вэ

## 21-р зуунд дараах чадварууд үнэд орно

Монгол орон эрс тэс уур амьсгалтай, тархай бутархай амьдарч байсан улс. Хөдөө амьдарч байгаа айлд асуудал гарвал бүх асуудлыг өөрсдөө л шийднэ. Бидний давуу тал нь амьд үлдэх чадвар сайтай. Сул тал нь өөрийнхөө л асуудлыг шийддэг. Гэтэл хотожсон, суурышмал соёлтой өнөөгийн нийгэмд бусадтай хамтрах, аливаа асуудлыг глобал хэмжээнд ярих, хэлэлцэх, шийдэх шаардлага гарч байгаа юм. Бид өөрсдийн суурь давуу тал дээрээ тулгуурлаад илүү өргөн өнцгөөр алс хол харах шаардлагатай болж байна. Зөв монгол хүнийг бага сургуульд нь бэлдэх ёстой. Японд бага ангийн багш нар ахлах ангийн багш нараас өндөр цалин авдаг. Яагаад гэхээр бага ангийн багш нар нь япон хүнийг бэлтгэдэг бол ахлах ангийн багш нар зүгээр л хичээл заах статустай.

Тэгэхээр хүн болж төлөвшихийн 60,70 хувь нь долоон нас хүртлээ бүрэлдэж байгаа юм. Бага сургуульд нь бага боловсролоор нь дамжуулан илүү системтэй бэлдэх нь чухал. Харин их сургуульд бол дэлхийн хүнийг л бэлдэх ёстой юм. Их сургуульд дөрвөн зүйлд анхаарч, сургалтаа явуулах ёстой. Нэгд, мэдэхэд сургана, чадварт сургана, хувь хүнийг хөгжүүлнэ. Нөгөө нэг зүйл нь нийгэмд бусадтай хамтрах ёстой

учраас бие хүний хувьд төлөвшүүлэх ёстой. Энэ дөрвөн чадварыг олгох нь их сургуулийн үүрэг. 21-р зуунд үнэд орох чадварууд бол аливаа асуудлын учрыг олдог шийдэл гаргаж чаддаг, хамтарч чаддаг, харилцааны чадвар. Нөгөө талаас шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлч сэтгэлгээ байх ёстой. Толгой өвдөж байна гэж хариулдаг хүн биш, толгой өвдөхөд хүний биед ямар процесс явагддаг вэ, анальгин уухад ямар нөлөөл үзүүлдэг, тэр эм ямар бүтэц, найрагатай вэ, анальгиныг өөр ямар зүйлээр орлуулж, толгойн өвчнийг намдааж болох уу гэдэг шийдлийг олж чаддаг хүн болох ёстой.



Энэ нь аливаа асуудлын нарийн учрыг олдог, шийдэл гаргаж чаддаг чадварыг хэлж байгаа юм.

Их сургуулиас диплом олж авах нь чухал, түүнээс илүү чухал нь аливаа зүйлийг мөн чанарыг ойлгодог, асуудалтай мэргэжлийн үүднээс хандаж, харилцаж чаддаг чадварыг эзэмших нь чухал. Бакалаврын сургалт бол хүүхдэд тухайн мэргэжлийн шинэ зүйлийг сурахад шаардлагатай суурь мэдлэг чадварыг л олгож байгаа юм.

Том компаниуд ажилд авахдаа тухайн хүний диплом, дүн, оноог нь бус яагаад энэ ажлыг сонгосон бэ, зорилго байна уу, баг байна уу, санаа байна уу гэдэг гурван зүйлийг л хардаг.

Аливаа өгөгдлийг цэгцлэхээр мэдээлэл болж байгаа юм, мэдээллийг цэгцлэхээр мэдлэг болж байгаа. Мэдлэгийг тунгаахаар сэц болно. Хуучин бол хэн мэдээлэлтэй байна, тэр хүн давуу талтай байсан. Одоо бол хэн өгөгдлөтэй байна, түүнээсээ хэрхэн мэдээлэл боловсруулж чадаж байна. Мэдээлэлд шинжилгээ хийж, боловсруулж чаддаг чадвар чухал юм. Мэдээлэл асар хурдтай хөвж байна. Шүүн тунгаах, цэгцлэн боловсруулах чадвар шаардана. Нөгөө талаас залуус бусдын туршлага, ноу-хау мэдэж, өвлөж авах нь чухал юм. Нэг гуталчин залуу байж. Тахалсан гутлууд нь бүгд салж унаад байсан байна. Харин багшийнх нь хадсан гутал салахгүй байж. Багштайгаа хамт сууж байгаад яг


яг ижилхэн хадаасаар, адилхан арга барилаар хадсан чөөрийнх нь хадсан хадаас богино хугацааны дараа салж унаад байсан байна. Гайхширсан залуу багшаасаа учрыг лавлахад хадаасаа хадахын өмнө норгож, шүлстэх ёстойг хэлжээ. Номон дээр хадаасаар тах хадна гээд биччихсэн байдаг. Гэхдээ шүлстэхийг хэн ч мэдэхгүй. Ажлын байран дээр гарч байж л сурдаг. Амжилтад гурван зүйл чухал. Тэр нь итгэл, сэтгэл, зүтгэл. Тесла компани цомхтгол хийхдээ Тесла номер нэг машин үйлдвэрлэгч болно гэдэгт итгээгүй хүмүүсээ халсан гэдэг. Зорилгодоо итгэхгүй байгаа хүн хол явахгүй.

*Эх сурвалж: <http://itoim.mn/article/oQWiX/14548?fbclid=IwAR1WdaizwA2Ve-OJ2GltQCN3uvRBJqjquwS2ykGDbyK4NI8K4opom4BkFilc>*

# Анхаарлын эдийн засагт та үнэт цагаа үрсээр байна уу?

Бид гайхалтай цаг үед амьдарч байна. Хязгаартгүй мэдээлэл, харилцаа, ухаалаг утас, интернэтийн ачаар хурууны үзүүрт бүх зүйл хөдлөх мэт. Гэхдээ бидэнд байхгүй зүйл бол хязгаартгүй цаг хугацаагаар анхаарал төвлөрүүлэх чадвар юм.

Цаг хугацааг өөрт буй хамгийн үнэтэй баялаг хэмээн үнэлж эхэлбэл хамгаалж эхэлдэг. Анхаарлын эдийн засагт өөрийн анхаарлыг хэрхэн хуваарилахад суралцах нь нэн чухал ур чадвар болоод байна.



Гар утас, апликеийшн, вэб хуудас зэрэг таны харцыг булааж, анхаарлыг татах бүтээгдэхүүнүүд их болж. Хэвлэлийн компаниуд албаар уур хүргэмээр гарчиг сонгодог. Хүн бүр эерэг мэдээлэл уншимаар байна гэдэг ч эсрэгээрээ тодорхойгүй эсвэл золгүй явдлыг илүү сонирхож уншдаг нь олон жилийн тоон үзүүлэлтээр нотлогдсон зүйл. Тэд үүнийг мэддэг ч давуу талаа болгон, таныг өдөөн хатгасан гарчиг бичсээр л байна. Таны анхаарлыг татаж чадвал тэдний бизнес амжилттай хэмээнэ.

**Энгийн асуултаас эхэльье. Та гар утсаа зорилгоо гүйцэлдүүлэх, мөнгө олох хэрэгсэл болгон ашиглаж байна уу  
эсвэл гар утас таныг ашиглаад байна уу?**

Өөрийн мэдэлгүй фэйсбүүк пост доош гүйлгэж байхдаа “Та бол бүтээгдэхүүн, таны анхаарлыг тэд худалдан авч байна” гэдгийг өөртөө үргэлж сануулаарай. Таны харсан зар болгоны ачаар фэйсбүүк мөнгө олж байдаг. Мөн таны анхаарал худалдааны зах зээлд орж нэг нь зараад нөгөө нь худалдан авч, компаниуд ашиг олж байдаг нь гашуун ч гэсэн үнэн юм.

Хэрэв амьдралаа баялаг болгохыг хүсвэл хамгийн үнэтэй баялагаа зөв зарцуулаарай.



# АЛТАН ГИШҮҮН

Biznetwork.mn нь 4800 гаруй гишүүн байгууллагатай хамтран ажилладаг.  
Энэ удаагийн дугаарт доорх АЛТАН ГИШҮҮН байгууллагуудаа онцолж байна.

## АРИГ БАНК



Ариг банк нь 1997 онд анх байгуулагдсан ууган арилжааны банкны нэг юм. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод 7 салбар, Дархан-Уул аймгийн Дархан хотноо 2 салбар, нийт 9 салбар нэгжтэйгээр 150 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.



## ТЕСО КОРПОРАЦИ



Дэлхийд өрсөлдөнө уриатай Тэсо корпорацийн үндэс суурь 2003 оноос улбаатай бөгөөд богино хугацаанд Үндэсний томоохон үйлдвэрлэгч болж чаджээ. Оновчтой шийдвэр зоригтой алхам, чадварлаг баг хамт олны нөр их хөдөлмөрийн ачаар өдгөө салбар бүрт манлайлж буй 14 компанийг байгуулж өмнөө тавьсан зорилгодоо хүрэхээр алхам алхмаар урагшилсаар байна. Тэсо корпораци нь удирдлага, менежментийн цар хүрээг корпорацийн хэмжээнд төлөвлөн хүнс, хүнсний бүтээгдэхүүн, барилга байгууламж, уул уурхай, зам тээвэр, гадаад харилцаа, импорт, экспортын чиглэлээр амжилтай ажиллаж байна.

### Бизнесийн чиглэл



## ШУНХЛАЙ ГРУПП



“Шунхлай” ХХК нь 1993 онд авто засварын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Улаанбаатар хот болон орон нутагт 90 гаруй шатахуун түгээх станц, газрын тосны бүтээгдэхүүний 8 агуулах, бүтээгдэхүүний хүргэлт, түгээлтийг хариуцсан авто бааз, улсын итгэмжлэгдсэн лабораторитой үйл ажиллагаагаа явуулж байна.



## АЛТАЙ ХОЛДИНГ



Анх 1991 онд “Алтай Трейдинг” ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, гадаад дотоод худалдаа, ноолууран бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар худалдаа үйлчилгээ, зочид буудал болон харилцаа холбоо, мэдээллийн технологи зэрэг олон салбарт хөрөнгө оруулалтыг хийн амжилттай өсөн дэвшиж буй үндэсний томоохон компаниудын нэг юм.

